

ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БА ЭКО ТЭМДЭГ STeP ECO LAB ТӨСӨЛ



Дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн замналыг сонгож, байгаль орчин, нийгэм болон эдийн засгийн асуудлуудыг эн тэнцүү хөгжүүлэхэд түлхүү анхаарч байна. Бодлогын өөрчлөлтөө дагаад эдийн засгийн хөгжлийн томоохон салбарууд, тэр дундаа нэхмэл, хувцасны салбарын үйлдвэрлэгчид стратегийн бодлого, чиглэлээ эргэн харж, нийлүүлэлтээс хэрэглээ хүртэлх нийлүүлэлтийн сүлжээнд тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зарчмуудыг нэвтрүүлэхийг чухалчилж, өөрчлөгдөн хувьсаж байна.

Уламжлалт нүүдлийн мал аж ахуйд суурилсан ноос ноолуурын салбар нь Монголын эдийн засгийн хоёрдогч гол хөдөлгөгч хүч юм. Монгол улсын засгийн газраас ноос ноолуурын салбарт сүүлийн жилүүдэд түлхүү анхаарч, хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг хангах стратегийн зорилтуудаа хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулж, тусгасан байдаг.

STeP EcoLab төсөл нь дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж малчнаас хэрэглэгч хүртэлх тогтвортой түүхийн эдийн нийлүүлэлт ба үйлдвэрлэлийг нийлүүлэлтийн сүлжээний үе шат бүрт нэвтрүүлж, Монголын тогтвортой түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол болон Европын зах зээлтэй холбоход дэмжлэг үзүүлж байна.



ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр

Монголын нэхмэлийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг (STeP EcoLab)

Нийт төсөв

2,320,755 Евро, Европын Холбооны SWITCH ASIA хөтөлбөр (80%)

Хугацаа

2018-2022



Төслийн зорилтот бүлгүүд

ЖДҮ (~80)

Мэргэжлийн холбоод (3)

Малчин өрх (~5000)

Хоршоолол ба БАХ- 30

Засгийн газар ба бодлого тодорхойлогчид

Монголын боловсролын салбар (ШУТИС)

Монгол ба Европын хэрэглэгчид (~1,500,000)

Европ дахь нэхмэлийн компаниуд

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

AVSF Монгол байгууллагаас Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг - STeP EcoLab" төсөл нь малчнаас хэрэглэгч хүртэлх нэмүү өртгийн сүлжээний үе шат бүрт тогтвортой үйлдвэрлэлийг нэвтрүүлж, Монголын тогтвортой ноос, ноолууран бүтээгдэхүүнийг Монгол, Европын зах зээлд сурталчилахад дэмжлэг үзүүлдэг.



Тогтвортой түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах

Боловсруулах үйлдвэрүүд байгальд ээлтэй арга технологийг нэвтрүүлэх



Ногоон санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх

Тогтвортой ноос ноолууран бүтээгдэхүүнийг Монголын болон Европын зах зээлд сурталчилах



Төсөл хэрэгжих газрууд:

Улаанбаатар хотын ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрүүд
Баянхонгор, Говь-Алтай, Архангай аймгийн ямааны ноолуур, сарлагийн хөөвөр, тэмээний ноос бэлтгэгч хоршоод



ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

AVSF Монгол байгууллагын "Тогтвортой ноолуур" Холбоо болон Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран байгальд ээлтэй тогтвортой түүхий эд бэлтгэх, түүхий эдийн чанарыг хянах, сайжруулах, түүнийг гэрчилгээжүүлэх чиглэлээр хийгдэж буй оновчтой арга туршлагуудыг сурталчлан таниулах

Монголын ноос, ноолуурын холбоотой хамтран нэхмэлийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийн замын зураг, Монголын ноос, ноолуурын салбарын "Тогтвортой үйлдвэрлэлийн сайн дурын дүрмийг (Voluntary Code of Practice) боловсруулж, хэрэгжүүлэх

Германы Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны төв болон Байгаль орчны аюулгүй байдлын төвтэй хамтран нэхмэлийн салбарын боловсруулах үйлдвэрүүдийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлж, түүнийг сайжруулах арга замуудыг тодорхойлох.

Монголын банкуудын холбоотой хамтран нэхмэлийн салбарын онцлогийг тусгасан байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ болон бусад холбогдох гарын авлага, арга хэрэгслийг боловсруулах.



МОНГОЛЫН
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО



"Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг - STeP EcoLab" төсөл

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, MGG байрны 4 давхар
Утас: +976-70110043

Энэ нугалбар Европын Холбооны санхүүжилтээр хэвлэгдэв. Хэвлэлд дурдагдсан аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг AVSF Mongolia бүрэн хариуцах бөгөөд Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй байж болно.